



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 4/37

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалт, Хууль сахиулахын их сургуулийн дүрмийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 12.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "2016-2017 оны хичээлийн жилийн бакалаврын элсэлтийн шалгалтын журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Сургалтын хэлтсийн дарга /цагдаагийн дэд хурандаа Л.Мандах/, Соёл, олон нийт, хамтын ажиллагааны албаны дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Энхболд/ нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал /дэд комиссар Б.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

ЗАХИРАЛ, ПРОФЕССОР,
ТЭРГҮҮН КОМИССАР

С.БААТАРЖАВ

ХУУЛБАР ҮНЭН
ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА, В.БЯМБАСҮХ



Хууль сахиулахын их сургуулийн захирлын
2016 оны 11 сарын 21 ны өдрийн 11 дугаар
тушаалын хавсралт

2016-2017 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН БАКАЛАВРЫН ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ЖУРАМ

УХДН272 1701252

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Хууль сахиулахын их сургууль /цаашид “Их сургууль” гэх/-ийн 2016-2017 оны хичээлийн жилийн бакалаврын элсэлтийн шалгалтыг зохион байгуулахтай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Элсэлтийн шалгалтыг зохион байгуулахад Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаал /Оюутан элсүүлэх журам батлах тухай/, 2014 оны А/143 дугаар тушаал /Элсэлтийн чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай/, Хууль зүйн сайдын 2015 оны А/148 дугаар тушаал /Хууль сахиулахын их сургуулийн дүрэм батлах тухай/, захиалагч агентлаг, байгууллагуудын хүний нөөцийг бэлтгэх, сонгон шалгаруулахтай холбогдох харилцааг зохицуулсан бусад хууль тогтоомж болон энэ журмыг баримтална.

1.3. Элсэлтийн шалгалтыг Элсэлтийн шалгалтын комисс /цаашид “Комисс” гэх/ зохион байгуулна. Комиссын бүрэлдэхүүнд захиалагч агентлаг, байгууллагын төлөөллийг оруулна.

1.4. Комиссын дарга элсэлтийн шалгалтын бэлтгэл ажлыг хангах, нэмэлт шалгалтын агуулга, даалгавар боловсруулах үүрэг бүхий ажлын дэд хэсгийг байгуулж, өдөр тутмын удирдлагаар хангана.

1.5. Элсэлтийн шалгалтад элсэхийг хүсэгчийн төлөөлөл болон бусад эрх бүхий субъект хууль тогтоомжийн хүрээнд хөндлөнгийн хяналт тавина.

1.6. Элсэлтийн нэмэлт шалгалт, зарим бүртгэлийг Их сургуулийн төв байранд зохион байгуулах ба энэхүү журмаар тогтоосон хугацаанд элсэхийг хүсэгч биечлэн оролцоно.

1.7. Элсэлтийн шалгалттай холбогдох мэдээллийг Их сургуулийн www.leu.gov.mn цахим хуудсанд байршуулж, нийтэд мэдээлнэ.

Хоёр. Элсүүлэх хөтөлбөрийн чиглэл, сургалтын хэлбэр

2.1. Их сургууль нь 2016-2017 оны хичээлийн жилд дараах бакалаврын хөтөлбөрүүдэд элсүүлэн суралцуулна.

№	Хөтөлбөрийн нэр, индекс	Шалгалтын чиглэл, босго оноо		Нэмэлт шалгалт	Хугацаа
		Суурь	Хавсралт		
Өдрийн сургалт /Иргэн, захиалагч байгууллагын алба хаагч/					
1	“Цагдаа- хууль сахиулах ажил” /D103201/	Нийгмийн тухай мэдлэг. <u>Босго оноо:</u> 400	Математик, Гадаад хэл /сонгох/ <u>Босго оноо:</u> 400	Эрүүл мэнд	4 жил


2	Онцгой байдал- гамшгаас хамгаалах алба /D103205/	Математик <u>Босго оноо:</u> 400	Нийгмийн тухай мэдлэг, Гадаад хэл /сонгох/ <u>Босго оноо:</u> 400	Бие бялдрын шалгалт	4 жил ХХД02721701282
3	"Хилийн алба" /D103802/	I бүлэг: Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 400	Математик, Гадаад хэл /сонгох/ <u>Босго оноо:</u> 400	Сэтгэл зүйн сорил	
		II бүлэг: Математик <u>Босго оноо:</u> 400	Гадаад хэл Физик /сонгох/ <u>Босго оноо:</u> 400		4 жил
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-хууль сахиулах ажил /D103202/ /Зөвхөн алба хаагч/	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 400	Математик, Гадаад хэл /сонгох/ <u>Босго оноо:</u> 400	Нэмэлт шалгалт авахгүй	4 жил
5	Эрх зүй /D041201/	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 400	Математик Гадаад хэл /сонгох/ <u>Босго оноо:</u> 400		4 жил
Эцнээ сургалт /Захиалагч байгууллагын алба хаагч/					
1	Цагдаа-хууль сахиулах ажил /D103201/	Нийгмийн тухай мэдлэг <u>Босго оноо:</u> 400	Элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн аль нэг хичээлийг сонгох <u>Босго оноо:</u> 400	Нэмэлт шалгалт авахгүй	5 жил
1	Цагдаа-хууль сахиулах ажил /D103201/	Нийгмийн тухай мэдлэг	Математик Гадаад хэл /сонгох/	Шалгалтын нийт онооны 60 хувь	3 жил
2	Хилийн алба /D103802/				
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-хууль сахиулах ажил /D103202/				

2.2. Нэмэлт шалгалтад орох элсэхийг хүсэгчийн тоо нь тухайн хөтөлбөрт элсүүлэх элсэгчдийн хяналтын тоо, захиалагч агентлаг, байгууллагын саналаас хамаарч хөтөлбөр бүрт ялгамжтай байна. Өдрийн сургалтад элсэхийг хүсэгч иргэн, алба хаагчдын хяналтын тоог тус, тусад нь тогтооно.

2.3. Их сургуулийн элсэлтийн цахим бүртгэлд бүртгүүлсэн элсэхийг хүсэгчийг элсэлтийн ерөнхий шалгалтын сонгогдсон хичээлүүдийн онооны нийлбэрээр буурах эрэмбээр жагсаана. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас баталсан хяналтын тоог 30 хувиар нэмэгдүүлсэнтэй тэнцэх тооны элсэхийг хүсэгч нэмэлт шалгалт, судалгаанд хамрагдах эрхтэй.

(Жишээлбэл: Нэг хөтөлбөрөөр элсүүлэх хяналтын тоог Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас 100 байхаар баталсан тохиолдолд цахим бүртгэлд бүртгүүлсэн элсэхийг хүсэгчдийн жагсаалтын эхний 130 элсэхийг хүсэгч нэмэлт шалгалтад орох эрхтэй болно.)

2.4. Бакалаврын өдрийн сургалтад бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой иргэн, захиалагч агентлаг, байгууллагын албан хаагчийг, эчнээ 5 жилийн сургалтад бүрэн дунд боловсролтой, эчнээ 3 жилийн сургалтад дээд боловсролтой захиалагч агентлаг, байгууллагын алба хаагчийг тус тус элсүүлнэ.



Гурав. Элсэхийг хүсэгчид тавих шаардлага

3.1. Элсэхийг хүсэгчид дараах нийтлэг шаардлага тавигдана:

3.1.1. Бүрэн дунд боловсролтой элсэхийг хүсэгч нь 2016 онд монгол хэл, бичгийн шалгалтыг заавал өгч, 400 буюу түүнээс дээш оноо авсан байх;

3.1.2. Сонгосон хөтөлбөрт хамаарах хичээлүүдийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноо нь энэ журмаар тогтоосон босго онооноос багагүй байх;

3.1.3. Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж хүчинтэй байх;

3.2. Элсэхийг хүсэгч иргэнд тавих тусгай шаардлага:

3.2.1. Эрэгтэй, 17-25 хүртэл насны, 168 см буюу түүнээс дээш өндөртэй байх;

3.2.2. Нүүрний хэлбэр төрх зөв, ил харагдах 20X05мм-ээс том сорви, шивээсгүй, бие эрхтний гэмтэл согоггүй, эрүүл байх;

3.2.3. Ял шийтгэлгүй байх;

3.2.4. "Цагдаа-хууль сахиулах ажил" хөтөлбөрт элсэгч ял шийтгэгдэж байгаагүй, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт зааснаар захиргааны шийтгэлийг эдэлж дууссанаас хойш 1 жилийн хугацаа өнгөрсөн байх,

3.2.5. Захиалагч агентлаг, байгууллагын зан байдал, хандлага, ёс зүйн судалгаанд тэнцсэн байх;

3.2.6. Нэмэлт шалгалт, Цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл сургалтад тэнцсэн байх;

3.3. Энэхүү тусгай шаардлага нь "Эрх зүй" хөтөлбөрт элсэхийг хүсэгч иргэнд хамаарахгүй.

Дөрөв. Элсэхийг хүсэгчдийн бүртгэл

А.Элсэхийг хүсэгч иргэн

4.1. Их сургуулийн www.leu.gov.mn хаягаар нэвтрэн орж, элсэлтийн бүртгэлийн санд цахим хэлбэрээр 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрүүдэд зөвхөн нэг хөтөлбөрийг сонгож бүртгүүлнэ.

4.2. Нэмэлт шалгалтад орох нэрсийн жагсаалтад багтсан элсэхийг хүсэгч элсэлтийн цахим бүртгэлийн сангаас "Хууль сахиулахын их сургуулийн шалгалтын хуудас"-аа хэвлэж, Улаанбаатар хотын элсэхийг хүсэгч иргэд 2015 оны 07 дугаар сарын 02-03-ны өдөр, хөдөө орон нутгаас элсэхийг хүсэгч иргэд 2015 оны 07 дугаар сарын 03-04-ний өдөр Их сургуулийн төв байранд биечлэн ирж бүртгүүлнэ.

4.3. Бүртгүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлж ирнэ. Үүнд:

-Иргэний үнэмлэх /нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт/

-Бүрэн дунд боловсролын гэрчилгээ /нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт/

-Дээд боловсролтой иргэний хувьд бакалаврын диплом, хавсралт, /нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт/

- 2016 оноос өмнө Элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн бол батламж /эх хувиар/

- Их сургуулийн элсэлтийн цахим бүртгэлийн сангаас хэвлэсэн “Шалгалтын хуудас”
- 3Х4 хэмжээтэй цээж зураг 4 хувь



Б. Элсэхийг хүсэгч албан хаагч

4.4. Захиалагч агентлаг, байгууллагууд бакалаврын хөтөлбөрийн 3 жилийн эцнээ сургалтад элсэхийг хүсэгч албан хаагчдын нэрсийн жагсаалт, холбогдох судалгааны материалыг нэгтгэн 2016 оны 05 дугаар сарын 01-ний дотор, өдрийн 4 жил, эцнээ 5 жилийн сургалтад элсэхийг хүсэгч алба хаагчдын нэрсийн жагсаалтыг 2016 оны 07 дугаар сарын 05-ны дотор Комисст ирүүлнэ.

4.5. Бүртгүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлж ирнэ. Үүнд:

- Иргэний үнэмлэх, албаны үнэмлэхний хуулбар
- Бакалаврын боловсролын диплом, хавсралт /Нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/
- Төрийн албан хаагчийн анкет /маягт 1/
- Агентлаг, байгууллагын суралцахыг дэмжсэн шийдвэр
- 3Х4 хэмжээтэй цээж зураг 4 хувь

Тав. Элсэлтийн шалгалтын зохион байгуулалт

А.Элсэхийг хүсэгч иргэн

5.1. Бакалаврын “Эрх зүй” хөтөлбөрөөс бусад хөтөлбөрт элсэхийг хүсэгч иргэдийн тусгай шаардлага хангаж байгаа эсэх судалгаа, нэмэлт шалгалтыг дараах байдлаар зохион байгуулна.

5.1.1. Элсэлтийн нэмэлт шалгалтад орох эрхтэй элсэхийг хүсэгчийн ял шийтгэлтэй эсэх судалгааг 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдөрт багтаан зохион байгуулна. Ял шийтгэлтэй холбогдох тусгай шаардлагыг хангаагүй элсэхийг хүсэгч нэмэлт шалгалтад орохгүй бөгөөд Комисс бүртгэлээс хасна.

5.1.2. Нэмэлт шалгалтыг дараах хуваарийн дагуу зохион байгуулна.

№	Нэмэлт шалгалтын төрөл		Зохион байгуулах хугацаа	Зохион байгуулах газар
1.	Эрүүл мэндийн үзлэг	Улаанбаатар хотын элсэхийг хүсэгч	2016.07.04 2016.07.05	Хууль сахиулахын их сургууль, Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг
		Хөдөө орон нутгаас элсэхийг хүсэгч	2016.07.05 2016.07.06	
2.	Бие бялдрын шалгалт	Улаанбаатар хотын элсэхийг хүсэгч	2016.07.06 2016.07.07	Хууль сахиулахын их сургууль
		Хөдөө орон нутгаас элсэхийг хүсэгч	2016.07.07 2016.07.08	
3	Сэтгэл зүйн сорил	Нийт элсэхийг хүсэгч	2016.07.09	Хууль сахиулахын их сургууль

5.1.3. Эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн элсэхийг хүсэгч бие бялдрын шалгалтад хамрагдана.

5.1.4. Бие бялдрын шалгалтыг дараах шалгуураар авна. Элсэхийг хүсэгч “Хүч”, “Тэсвэр”, “Уян хатан”, “Хурд”, “Авхаалж самбаа” гэсэн бүх төрөлд заавал

хамрагдах бөгөөд авсан оноо нь нийт авбал зохих онооны 50%-д хүрэхгүй тохиолдолд шалгалтад тэнцэхгүйд тооцно.



А. Эрэгтэй

Д/д	Хүч	Тэсвэр	Хурд	Авхаалж самбаа	Уян хатан	Оноо
	Гар дээр суниалт	1000м	100м	Цогцолбор дасгал	Сууж урагш бөхийх	
1.	62	3.15	14.00	115	65	20
2.	60	3.20	14.10	114	64	19
3.	58	3.25	14.20	113	63	18
4.	56	3.30	14.30	112	62	17
5.	54	3.35	14.40	111	61	16
6.	52	3.40	14.50	110	60	15
7.	50	3.45	14.60	109	59	14
8.	48	3.50	14.70	108	58	13
9.	46	3.55	14.80	107	57	12
10.	44	4.00	14.90	106	56	11
11.	42	4.05	15.00	105	55	10
12.	40	4.10	15.10	104	54	9
13.	39	4.15	15.20	103	53	8
14.	38	4.20	15.30	102	52	7
15.	37	4.25	15.40	101	51	6
16.	36	4.30	15.50	100	50	5
17.	35	4.35	15.60	99	49	4
18.	34	4.40	15.70	98	48	3
19.	33	4.45	15.80	97	47	2
20.	32	4.50	15.90	96	46	1

Б. Эмэгтэй

д/д	Хүч	Тэсвэр	Хурд	Авхаалж самбаа	Уян хатан	Оноо
	Гар дээр суниалт	1000м	100м	Цогцолбор дасгал	Сууж урагш бөхийх	
1.	40	3.50	15.00	90	65	20
2.	38	3.55	15.10	89	64	19
3.	36	3.60	15.20	88	63	18
4.	34	4.00	15.30	87	62	17
5.	32	4.05	15.40	86	61	16
6.	30	4.10	15.50	85	60	15
7.	28	4.15	15.60	84	59	14
8.	26	4.20	15.70	83	58	13
9.	24	4.25	15.80	82	57	12
10.	22	4.30	15.90	81	56	11
11.	18	4.35	16.00	80	55	10
12.	16	4.40	16.10	79	54	9
13.	14	4.45	16.20	78	53	8
14.	12	4.50	16.30	77	52	7
15.	10	4.55	16.40	76	51	6
16.	8	4.60	16.50	75	50	5
17.	6	5.00	16.60	74	49	4
18.	4	5.05	16,70	73	48	3
19.	2	5.10	16,80	72	47	2
20.	1	5.15	16,90	71	46	1

5.1.5 Бие бялдрын шалгалтад тэнцсэн элсэхийг хүсэгч сэтгэл зүйн сорилын шалгалтад хамрагдана.

5.1.6 Элсэхийг хүсэгчийн "Сэтгэл зүйн сорил"-ыг сэтгэц зүйн байдал, оюуны чадамжийн түвшинг тогтоох зорилгоор авч "Тэнцэнэ", "Тэнцэхгүй" гэсэн дүгнэлт

гаргана. Сэтгэл зүйн сорилд тэнцэхгүй дүгнэлт гарч, маргаан үүссэн тохиолдолд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

5.1.7 Бакалаврын хөтөлбөрийн 4 жилийн сургалттай өдрийн ангид элсэхийг хүсэгч дээд боловсролтой иргэн сонгосон хөтөлбөрт хамаарах суурь ба хавсралт шалгалтыг 2016 оны 07 дугаар сарын 09-ний дотор зохион байгуулна.

5.1.8 Нэмэлт шалгалтыг дахин болон нөхөж авахгүй.

5.2 Нэмэлт шалгалтад тэнцсэн элсэхийг хүсэгчдийг элсэлтийн ерөнхий шалгалтын сонгогдсон 2 хичээлийн онооны нийлбэрийг буурах эрэмбээр жагсааж, Их сургуулийн элсэлтийн мэдээллийн самбар болон www.leu.gov.mn цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

5.3 Хөтөлбөр тус бүрээр элсүүлэх хяналтын тоонд багтсан элсэхийг хүсэгчид цэргийн хэргийн бэлтгэл сургалтад хамрагдана.

5.3.1 Цэргийн хэргийн бэлтгэл сургалтад хамрагдах элсэхийг хүсэгчид дараах баримт бичгийн бүрдлийг ханган 2016 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 09.00 цагт Их сургуулийн төв байранд биечлэн ирнэ. Үүнд:

- Иргэний үнэмлэх
- Эрүүл мэндийн даатгалын дэвтэр /2016 оны шимтгэлийг бүрэн төлсөн байх/;
- Гэнэтийн ослын даатгалын гэрээ;

5.3.2 Цэргийн хэргийн бэлтгэл сургалтыг Сургалт, дадлагын төвд 2016 оны 08 дугаар сарын 25-ны дотор багтаан 4-өөс доошгүй долоо хоногийн хугацаатай зохион байгуулна.

5.4 Цэргийн хэргийн бэлтгэл сургалтад хамрагдаж байгаа элсэгчдийн зан байдал, хандлага, ёс зүйн судалгааг 2016 оны 08 дугаар сарын 20-ны дотор захиалагч агентлаг, байгууллагатай хамтран зохион байгуулна.

Б. Элсэхийг хүсэгч албан хаагч


5.5 Захиалагч агентлаг, байгууллагаас ирүүлсэн бакалаврын хөтөлбөрийн 3 жилийн эчнээ сургалтад элсэхийг хүсэгч алба хаагчдын элсэлтийн шалгалтыг орон нутагт нь 2015 оны 05 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулж, тэнцсэн элсэгчдийн нэрсийг Их сургуулийн элсэлтийн самбар болон www.leu.gov.mn цахим хуудсаар нийтэд болон захиалагч агентлаг, байгууллагад мэдэгдэнэ.

5.5.1 Холбогдох агентлаг, байгууллагын хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгжийн зөвшөөрөлгүй бол элсэлтийн шалгалтад оруулахгүй.

5.6 Бакалаврын хөтөлбөрийн 4 жилийн өдөр, 5 жилийн эчнээ сургалтад элсэхийг хүсэгч алба хаагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтын сонгогдсон 2 хичээлийн онооны нийлбэрээр буурах эрэмбээр жагсааж, хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

Зургаа. Элсүүлэх шийдвэр гаргах

6.1 Их сургуулийн захирал Комиссын саналыг үндэслэн 2016-2017 оны хичээлийн жилд бакалаврын хөтөлбөрийн элсэлтийн шалгалтад тэнцсэн алба хаагчдыг элсүүлэн суралцуулах тухай тушаалыг 2016 оны 07 дугаар сарын 20-ны дотор, цахим бүртгэлд бүртгүүлсэн, нэмэлт шалгалт, захиалагч агентлаг, байгууллагын судалгаанд тэнцсэн, Цэргийн хэргийн бэлтгэл сургалтад бүрэн хамрагдсан элсэхийг хүсэгч иргэдийг элсүүлэн суралцуулах тухай тушаалыг 2016 оны 08 дугаар сарын 25-ны дотор гаргана.



Долоо. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх

7.1. Зөвхөн элсэлтийн үйл ажиллагаатай холбоотой өргөдлийг 2016 оны 07 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл Комиссын даргад, гомдлыг Их сургуулийн захиралд гаргана.

7.2. Өргөдөл, гомдлыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд шалган шийдвэрлэж, хариу өгнө.

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ